МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 12 өдөр Дугаар А/147 Алтай хот

Аймгийн аюулгүйн нөөцөд бэлтгэсэн
өвсийг хямдралтай үнээр худалдан
борлуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 11 дүгээр хурлын шийдвэрийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн аюулгүйн нөөцөд бэлтгэсэн 205.8 тонн буюу 10290 боодол өвсний нэг бүрийн үнийг 4,000 (дөрвөн мянган) төгрөгөөр худалдан борлуулсугай.

2.Тус захирамж гарсантай холбогдуулан 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/70 дугаар захирамжийн 1 дэх заалтын аймгийн аюулгүйн нөөцийн өвсийг хөнгөлөлттэй үнээр худалдаалах хэсгийг хүчингүй болгосугай.

3.Аймгийн аюулгүйн нөөцөд бэлтгэсэн өвс, тэжээлийн үнийн зөрүүг нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу данс бүртгэлд тусгахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Л.Насанбуян), нягтлан бодогч (Т.Галсан)-т тус тус зөвшөөрсүгэй.

4.Нөөцийн өвсийг дамлан худалдаалах зориулалт бусаар зарцуулах зэрэг зөрчлөөс сэргийлж, борлуулалт, түгээлтэд хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Л.Насанбуян), Мэргэжлийн хяналтын газар (Н.Сумъяабазар), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Ж.Мөнхцэцэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА О.АМГАЛАНБААТАР